



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар Д/616

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Соёлын ордны  
хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн  
бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 6,682,098 /зургаан сая зургаан зуун наян хоёр мянга ерэн найман/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Налайх дүүргийн Соёлын ордон /С.Баасанхүү/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Соёлын ордон /С.Баасанхүү/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115060001520

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 14 дугаар сарын 18 өдрийн 1/616 дугаар тушаалын хавсралт

Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Соёлын ордон

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт хүчин чадал	Ашиглалтад орсон огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдс ан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр		
								Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс	
	Тавилга, эд хогшил													
1	Тайзны цэцэг	1 сагстай	20 ш	2007.10.03	сайн	ш	2	96,459	192,918	192,918	-	Тавилга, эд хогшил	Хангамжийн данс	
2	Байгууллагын хаяг	Шар	1x2	2007.10.03	сайн	ш	1	97,680	97,680	97,680	-			
3	Хулдаас	Шаргал	100 м	2007.10.03	сайн	м	100	18,315	1,831,500	1,831,500	-			
Тавилга, эд хогшлын дүн								2,122,098	2,122,098	-				
Бусад үндсэн хөрөнгө														
4	Хөгжмийн кабель	хар	12в	2019.12.08	сайн	ш	300	3,000	900,000	105,000	795,000	Бусад үндсэн хөрөнгө		
5	Гэрэл тайзны	3w*54	220в	2007.12.28	сайн	ш	8	375,000	3,000,000	1,650,000	1,350,000			
6	Байгууллагын хаяг	Цагаан	1x2	2019.11.28	сайн	ш	1	660,000	660,000	110,000	550,000			
Бусад үндсэн хөрөнгийн дүн									4,560,000	1,865,000	2,695,000			
Нийт данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн дүн									6,682,098	3,987,098	2,695,000			